

## **ГУРВАН УЛС УЛАМ БҮР ИТГЭЛЦЭН, ОЙЛГОЛЦОХОД СОЁЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА ЧУХАЛ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ**

*Ч.Батцэцэг\**

Монгол Улс, хөрш орон ОХУ, БНХАУ-ын улс төр, эдийн засаг, худалдаа, уул уурхай, эрчим хүч болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагаа ойрын жилүүдэд маш эрчимтэй хөгжиж байна. Энэхүү гурван улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, улс хоорондын итгэлцэл, ойлголцлыг гүнзгийрүүлэх үйл хэрэгт соёлын хамтын ажиллагаа ихээхэн эерэг эрч хүч, улам хүмүүнлэг, илүү бүлээн дулаан уур амьсгалыг бүрэлдүүлэх чухал хүчин зүйл болохын сацуу томоохон үүрэг гүйцэтгэдэг.

Соёлын хамтын ажиллагаа бол хүмүүсийн хоорондын харилцаа бөгөөд тэдний оюун санааг холбон нэгтгэж, харилцан итгэлцэл, ойлголцол, найрамдал, хамтын ажиллагааг бий болгодог. Соёлын хамтын ажиллагаа нь улс хоорондын хамтын ажиллагааны үндсэн хэлбэрийн нэг байсан цаашид ч байх болно.

Монгол, Орос, Хятад гурван улсын ард түмэн өнө эртнээс оюун санаа болон соёлын уламжлалт барилдлагатай явж ирсэн баялаг түүхтэй. Өнөөгийн дэлхийн хөгжлийн чиг хандлагын өөрчлөлт, дэлхийн санхүү эдийн засгийн хямралын ийм нөхцөлд ч бид соёлын баялаг уламжлалт харилцаа, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн тэлэх учиртай. Өнөөдөр Монгол, Орос, Хятад гурван улсын өмнө орчин үеийн зах зээлийн харилцааны жам ёсны дагуу дэлхийн хөгжлийн чиг хандлагыг баримжаалан соёлын хамтын ажиллагаагаа улам бүр шинэлэг хэлбэрээр баяжуулан хөгжүүлэх сайхан боломж нээгдээд байна.

Монгол-Оросын соёлын хамтын ажиллагааны талаар авч үзэхүл, Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд 1995 оны 4 дүгээр сарын 5-нд Москва хотноо гарын үсэг зурсан соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг ярих ёстой. Уг Хэлэлцээрээр хоёр орны эрдэм шинжилгээний болон боловсролын байгууллагуудын хооронд шууд холбоо тогтоож хөгжүүлэх, түүнийг дэмжих зорилтыг онцолсон бөгөөд “соёл, шинжлэх ухааны харилцаа холбоо нь хоёр орны ард түмний найрамдал, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд чухал суваг болно”<sup>1</sup> хэмээн тодорхойлоод шинжлэх ухаан, боловсрол, соёл, утга зохиол, хэвлэл, хөгжим, театр, кино, радио, телевиз, аялал жуулчлалын салбарт хоёр орны холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг харилцан тэнцвэртэй, харилцан ашигтай ажиллах зарчмыг үндэслэн дэмжиж, тэтгэхээ илэрхийлсэн юм.

\* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) дэд профессор

Ийнхүү Монгол, Оросын холбогдох яам газруудын хооронд гэрээ, хэлэлцээр байгуулан шинжлэх ухаан, хүмүүнлэгийн болон соёлын салбарт хамтран ажиллах гэрээ, эрхийн үндсийг бүрдүүлж чадсан байна.

Шинжлэх ухааны байгууллагуудын хооронд байгуулагдсан гэрээ хэлэлцээрүүдийн дагуу монгол, оросын эрдэмтдийн хамтарсан геологи, геофизик, биологи, палеонтологи, археологи болон түүх, архив, соёлын суурь судалгааны хамтарсан экспедици ажиллаж, хоёр орны эрдэмтдийг харилцан солилцож, аспирантур, докторантурт сурч хамгаалуулах, хамтарсан бүтээл туурвих, хамтарсан эрдэм шинжилгээний хурал, симпозиум зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн арга хэмжээ явуулж ирлээ.

Мөн Монголын ШУА, ОХУ-ын ШУА-тай 2006-2010 онд хамтран ажиллах тухай академи хоорондын хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх хэлэлцээр байгуулав. 2007 онд Монгол Улс, ОХУ-ын Засгийн газрын хоорондын комиссын дэргэд шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны дэд комиссыг дахин шинээр байгуулжээ. 2008 оны 4 дүгээр сард Монгол Улсын ерөнхий сайд С.Баяр ОХУ-д айлчлах үеэр соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт 2008-2011 онд хамтран ажиллах 35 хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргажээ.<sup>2</sup> Үүнтэй холбогдуулан Монгол, Оросын эрдэмтдийн хэрэгжүүлж буй хамтарсан томоохон төслөөс “Төв Азийн ертөнц”, “Нүүдлийн соёл иргэншлийн түүх, соёлын асуудлууд”, “Монгол угсаатны түүх соёлын уламжлал” зэрэг судалгааг нэрлэж болно.

90-ээд оны эхнээс манай хоёр орны харилцаа хэсэг хугацаанд саарч, 1995 оноос харьцангуй тогтвортой болж, 2005 оноос эрчимжих хандлагатай болж байна. Энэхүү харилцааны сулралын үеийн байдал манай улсын боловсролын салбарын үйл ажиллагаанд нэг талаар сөргөөр нөлөөлсөн бол нөгөө талаас бас оюутан залуусыг гадаад хэл сурах, гадаад суралцах сонголт хийхэд таатай нөхцөл бүрдүүлсэн гэж үзэж болно. Сөрөг талаас нь авч үзвэл, *нэгдүгээрт*, өнгөрсөн зуунд манай улсын бага, дунд сургууль, их дээд сургуулиудын хичээлийн сургалтын хөтөлбөрт гадаад хэлний чиглэлээр зөвхөн орос хэлийг заадаг байсан бол 90-ээд оноос хойш орос хэлийг заавал сурах сургалтын хөтөлбөрөөс хасч, англи хэлийг албан ёсоор заах болж, бусад хятад, япон, солонгос, орос гэх мэт гадаад хэлийг сонгон суралцуулах болсон. *Хоёрдугаарт*, хуучнаар ЗХУ-ын их дээд сургуулиудад төрөл бүрийн мэргэжлээр оюутан суралцуулж, үндэстний боловсон хүчнээ бэлтгэж байсан нь хэсэг хугацаанд тасарсан юм. Үүнээс улбаалан Монгол Улсад орос хэлийг эзэмших залуусын тоо эрс цөөрч бүхэл бүтэн нэг үе орос хэл, утга зохиолоос хөндийрч, Орос орон, оросын ард түмний тухай ойлголт, мэдлэгээр тун дулимаг залуусын тоо нэмэгдсэн гэж үзэх талтай. Үүний учир шалтгааныг нэг талаас социализмын үеийн үзэл суртлын үр

дагавар хэмээн тайлбарлаж болох ч нөгөө талаас басхүү төрийн алдаатай бодлогын уршигтай холбож үзэх хэрэгтэй. Орчин үед хоёр хөршийнхөө эх хэлийг сурахын зэрэгцээ тэдний түүх, соёл иргэншил, хүн ам, эдийн засаг, бүтээн байгуулалтын туршлага гэх мэт олон талын сонирхолтой, баялаг асуудлыг танин мэдэх нь зайлшгүйн дээр бүхий л салбарт хоёр хөрштэй хамтран ажиллах нөхцөл шаардлага зайлшгүй тулгарсаар байна. Ялангуяа Монгол, Орос хоёр орны харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх нөхцөл бүрдэж байгаа өнөө үед орос хэлний хэрэгцээ, Орос улсад бэлтгэсэн төрөл бүрийн мэргэжилтэй боловсон хүчин дутагдаж, тэдгээрийг бэлтгэх шаардлагатай болж байна.

Гагцхүү 90-ээд оны дунд үеэс орос хэлээр хичээллэдэг хувийн, төлбөртэй бага дунд сургууль нээгдэж, үр хүүхдээ суралцуулах явдал идэвхжих хандлагатай болж ирсэн билээ. Улмаар Монгол Улсад Оросын их дээд сургуулиудын салбарууд анх удаа шинээр байгуулагдан ажиллаж, түүнд суралцах оюутнуудын тоо ч өссөөр байна. 1996 оноос эхлэн ОХУ Монголоос жил тутам 60 хүртэл оюутан, 30 хүртэл оюутан аспирант, мэргэжил дээшлүүлэгчдийг хүлээн авч сургаж байсан бол өдгөө 215 болтлоо квот нь өсчээ. Өнөөдөр ОХУ-ын 25 субъектын 25 хотын 126 их дээд сургуульд манай улсын оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэгч 1300-гаад хүн суралцаж байна.<sup>3</sup> Хамгийн сүүлийн жишээ дурьдахад, 2009 оны 3 дугаар сард Монгол Улсын ерөнхий сайд С.Баяр ОХУ-д айлчлах үеэр, Монголоос арваад оюутныг уул уурхайн салбарын чиглэлээр ОХУ-ын зардлаар суралцуулах гэрээнд БСШУ-ны сайд Ё.Отгонбаяр гарын үсэг зурсан юм.

Монгол Улс, ОХУ-ын соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болсон баримт бичгээс үзвэл, 1999 оны 3 дугаар сарын 31-нд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд шинжлэх ухаан, соёлын салбарт 1999-2001 онд хамтран ажиллах хөтөлбөр байгуулсан ба энэ хөтөлбөрийг үргэлжлүүлэх үүднээс 2002 оны 9 дүгээр сард Монгол Улсын БСШУ Яам, ОХУ-ын Боловсролын Яамны хоорондын Гэрээнд, мөн 2003 онд Монгол Улсын ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийх үеэр Монгол, Оросын Засгийн газар хооронд шинжлэх ухаан, соёлын салбарт 2003-2006 оны хооронд хамтран ажиллах Хөтөлбөрт тус тус гарын үсэг зурсан.<sup>4</sup> 2006 онд ерөнхийлөгч Н.Энхбаярын айлчлалын үеэр Монголын БСШУ Яам, ОХУ-ын соёл, кино урлагийн агентлагийн хооронд 2006-2008 оны хамтын ажиллагааны Хөтөлбөр, 2009 оны 3 дугаар сард Монгол Улсын ерөнхий сайд С.Баярыг ОХУ-д айлчлалын үеэр соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтран ажиллах Хөтөлбөр тус тус байгуулжээ.<sup>5</sup>

Ийнхүү Монгол Улс, ОХУ-ын хооронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж, хөтөлбөр, төслүүдийг амжилттай хэрэгжүүлж эхэлж байна.

Соёлын хамтын ажиллагааны хүрээнд хоёр талын найрамдлын нийгэмлэг болон найрамдлын сарын үйл ажиллагаа, соёлын өдрүүд, урлаг соёлын байгууллагууд, түүн дотор театр, дуу бүжгийн чуулга, кино, музей, номын сан, уран сайхны хамтлаг, уран бүтээлийн нэгдэл, уран бүтээлчдийн үйл ажиллагаа чухал байр эзэлдэг. 2007 онд Монгол-Оросын найрамдал нийгэмлэгийн 60 жилийн ойг өргөн тэмдэглэсэн. Энэ байгууллага нь хоёр орны найрамдлыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсаар ирсэн бөгөөд түүнчлэн Монгол дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төв (РЦНК) чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Монголын урлаг соёлын мэргэжилтэн, боловсон хүчний дийлэнхийг хуучин Орос улсад бэлтгэж байсны дотор дуурийн дуучид, балетын бүжигчид, хөгжимчид, зураачид, кино урлагийн мэргэжилтнүүд багтана. 90-ээд оноос хойш энэ салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг өөрийн эх орондоо бэлтгэж байна. Харин 2000 оноос хойш урлаг соёл, дүрслэх урлагийн салбарын чиглэлээр манай улсад суралцах ОХУ, БНХАУ-ын бүс нутаг, хил орчмын монгол үндэстэн-угсааны оюутнуудын тоо сүүлийн үед ихээхэн нэмэгдэж байна.

2003 оны 6 дугаар сард БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад хийсэн айлчлалын үр дүнд хоёр тал сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа тогтоон, өөрөөр хэлбэл хөгжлийн шинэ үе шатанд дэвшиж буйг хамтарсан мэдэгдэлд дурьдсан. Үүнээс хойш хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөжин амжилттай хөгжиж байна. Соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хооронд хамтран ажиллах хэлэлцээр, төлөвлөгөө байгуулсан бичиг баримтаас дурьдвал, 1994 онд “Монгол Улс, БНХАУ-ын соёлын хамтын ажиллагааны гэрээ”, 1998 онд “Монгол Улс, БНХАУ 1998-2000 онд соёлын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл”, 2001 онд “Монгол Улс, БНХАУ 2001-2003 онд соёлын солилцоо, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл”, “Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газраас 2004-2006 онд соёл урлагийн салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зурсан байна.

2004 оны 4 дүгээр сард БНХАУ-ын соёлын өдрүүдийг Монголд, 2005 оны 4 дүгээр сард Монголын соёлын өдрүүдийг Бээжин, Тяньжин хотод амжилттай зохион явуулав. Хэдийгээр соёлын өдрүүд богино хугацаанд болдог ч хоёр орны соёл урлагийн гайхамшгийг маш олон хүн үзэж сонирхох сайхан боломж нээгддэг.

Боловсролын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу өнөөдөр Монгол Улсаас 2300 гаруй оюутан БНХАУ-д суралцаж байна. Мөн 2005 онд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч У И манай улсад айлчлах үеэр ӨМӨЗО-ы Ардын Засгийн газрын тэтгэлгээр таван жил дараалан жилд 100 оюутан хүлээн авч суралцуулахаар тохирсоны дагуу өдгөө ӨМӨЗО-д 500 оюутан сурч байна.

Ийнхүү хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өргөжихийн хирээр манай улсад хятад хэлний хэрэгцээ өсч, хятад хэлний бага дунд

сургууль байгуулагдаж, улсын болон хувийн их дээд сургуульд хятад хэлний анги танхим, дугуйлан курс нээгдэж, суралцагсдын тоо нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар Монгол Улсад 20 гаруй бага, дунд сургууль, 30 гаруй их дээд сургуульд хятад хэлний хичээл орж байна. 2008 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо МУИС-ийн Күнзийн дээд сургууль албан ёсоор байгуулагдав. Мөн Хятадын их дээд сургуулиудтай холбоо тогтоож багш оюутан харилцан айлчилж, сургалтын туршлага солилцож байна. БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран “Хятад хэлний олимпиад”-ыг их дээд сургууль болон бага дунд сургуулийн хэмжээнд зохион байгуулдаг уламжлалтай болжээ.

Сүүлийн арваад жил хоёр орны шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах хууль зүйн үндэс суурь тавигдаж, амжилттай хөгжиж байна. Тухайлбал: 2005 онд Монгол Улсын ШУА, БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн хооронд хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурсан ба 2006 онд Монголын ШУА, БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яам 2006-2010 оны хооронд шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах хөтөлбөр байгуулан хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурж, хөтөлбөрийн дагуу хамтарсан төслүүд хэрэгжүүлж эхэлсэн ба эрдэм шинжилгээний ажилтнуудыг харилцан солилцож байна.<sup>6</sup>

Монгол Улсад хөрш орнуудынхаа бүс нутгийн хил орчмын монгол үндэстэн-угсаатантай нийлж соёлын өв уламжлалаа хадгалан сэргээх, баяжуулах, зааж сургах, нэг үндэстнийхээ давуу талаа ашиглах, хамтарсан урлаг соёлын бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээлд борлуулах талаар хамтран ажиллах таатай нөхцөл бүрдээд байна.

Гурван улсын соёлын хамтын ажиллагааны хүрээ үндсэндээ нийт улсын хэмжээнд болон бүс нутгийн шууд харилцаа буюу хил орчмын монгол үндэстэн-угсаатны хооронд орон нутгийн хэмжээнд өргөн дэлгэр явж ирсэн онцлогтой бөгөөд энэ харилцаа цаашид улам өсөх хандлагатай болж байна.

Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын бүс нутаг, хил орчим, субъект хоорондын хамтын ажиллагааны Дэд комиссын үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр 2000 оны 11 дүгээр сард Монгол Улсын ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин Монголд айлчлах үеэр гарын үсэг зурсан Монгол Улсын орон нутгийн захиргаад, ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай Хэлэлцээр хийсэн нь ач холбогдолтой боллоо. Уг Хэлэлцээрт ОХУ-ын хил орчмын Алтай, Буриад, Тувагийн Бүгд найрамдах улс, Эрхүү, Чита муж, Монгол Улсын хил орчмын Дорнод, Хэнтий, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийн хоорондын бүх талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай зааж,

хоёр талын гүйцэтгэх засаглалын байгууллагууд өөрсдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан хамтран ажиллах хууль эрхийн хэм хэмжээг тодорхойлсон.<sup>7</sup> Үүнээс улбаалан Монгол, Оросын бүс нутаг, субъект, муж, аймаг хот, хил орчмын нутгийн хооронд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт бие даан хамтран ажиллах, холбогдох яам, хороо, агентлаг, хамтлагуудын хооронд гэрээ, хэлэлцээр байгуулах, ялангуяа энэ салбарт хил орчмын монгол үндэстэн - угсаатны ард иргэдийн хоорондын харилцаа үр өгөөжтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл, боломж бүрэлдсэн юм.

Хэдийгээр Монгол Улс ОХУ-ын бүс нутаг, хил орчмын субъект, аймаг хотын хоорондох хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх таатай нөхцөл бүрдсэн ч хоёр тал тэр сайхан боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Монгол Улс хил залгаа, шууд харилцаатай ОХУ-ын Бүгд Найрамдах Алтай Улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Тува Улс, ОХУ-ын Эрхүү муж, ОХУ-ын Чита мужтай гол төлөв хилийн худалдаа, эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллахын зэрэгцээ боловсролын салбарт багш, оюутан солилцох, соёл хүмүүнлэгийн салбарын үйл ажиллагаа давамгайлах төлөвтэй байна. Цаашид энэхүү хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж, зах зээлийн харилцааны нөхцөл, шаардлагад нийцүүлэн улам боловсронгуй болгох, хөршийн харилцааны уламжлал, монгол туургатны нийтлэг сонирхлыг идэвхжүүлэх, нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглах боломжтой юм.

Харин Монгол Улстай нийтлэг соёлын баялаг, өв уламжлалаар өнө мөнхөд холбогдсон ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улстай тогтоосон уламжлалт харилцаа, эдийн засаг, худалдаа, соёл боловсрол, эрүүл мэнд, спорт гэх зэрэг бүхий л салбарын хамтын ажиллагаа харьцангуй идэвхжих хандлагатай байна.

Монгол, Буриадын хоорондын соёлын хамтын ажиллагааны хувьд хөгжим, дуурь бүжиг, драмын жүжгийн урлагийн салбарт 60-аад жил хамтран ажилласан баялаг туршлагатай. Сүүлийн жилүүдэд хоёр талын соёлын өдрүүдийг зохион байгуулахаас гадна орчин үеийн эстрад урлагийн дуучид, хамтлагууд, харилцан айлчлан тоглолт хийх, загварын үзүүлбэр, үзэсгэлэн гаргах, монгол туургатны дуу бүжгийн хамтарсан уралдаан тэмцээн явуулах, ойн арга хэмжээ зэрэг үйл ажиллагаа идэвхтэй явуулж, уран бүтээлч хувь хүмүүс тоглолт хийх, зураачид бүтээлээ танилцуулах явдал нэмэгдэж байна. Түүнчлэн хил орчмын бүс нутаг, аймаг, хот, орон нутгийн хэмжээнд шууд харилцаж ардын уламжлалт урлаг соёлын үйл ажиллагаагаа идэвхжүүлж байна. Үүний тод жишээ бол уламжлал болж буй урлаг соёлын наадам “Сагаалгана”, “Алтаргана”, “Эв мод” нийлүүлэх баярыг нэрлэж болно.

Монгол Улсад Буриадын их дээд, дунд сургуулийн салбарууд бий болж, ОХУ-ын ШУА-ийн Дорнод Сибирийн салбартай шинжлэх ухааны чиглэлийн хамтын ажиллагааг өргөтгөх, эрүүл мэндийн салбарт

монголын уламжлалт анагаах ухааны эмнэлгийн чиглэлээр хамтран ажиллах зэрэг шинэ шинэ хэлбэрийн ажлыг амжилттай эхлүүлээд байна.

Монгол Улс, ОХУ-ын соёл, боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд хоёр талын идэвхи санаачлага, бодит амьдралд хэрэгжүүлэх олон хэлбэрийн шинэлэг арга ажиллагаа чухал болж байна.

Мөн 2005 онд Монгол Улсын БСШУЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хооронд шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний дагуу хэд хэдэн төсөл хэрэгжүүлэх болж, уламжлалт анагаах ухаан, Монголын бэлчээрийн экологи, Улаанбаатар, Хөх хотын хот байгууламжийг харьцуулсан дүн шинжилгээ гэх мэт олон судалгаа хийгдэж байна. Ялангуяа 2000 оноос байгаль экологийг хамгаалах талаар хамтарсан судалгаа явуулж, хил орчмын хязгаар нутгийн цөлжилт, шороон шуургатай тэмцэх асуудлаар эрдэм шинжилгээний хурал, семинар тогтмол зохион байгуулж, тухайн мэргэжлээр урт, богино хугацааны сургалтанд манай эрдэм шинжилгээний ажилтнуудыг БНХАУ-д сургаж байна. Мөн Монгол Улсад Өвөр Монголын эрдэмтэд мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг цол хамгаалахаас гадна, судалгааны хамтарсан бүтээл, ном туурвиж, хэвлүүлж байна.

Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хооронд соёлын хамтын ажиллагаа 2000 оноос улам эрчимжихийн зэрэгцээ хоёр талын хил залгаа аймаг, хотын хооронд шууд харилцаа тогтож, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах болжээ. Соёлын хамтын ажиллагааны хүрээнд соёлын өдрүүд, кино, радио телевизийн өдрүүд, сар шинийн уламжлалт баярын концерт онцгой чухал байр эзэлдэг. Тухайлбал: Монгол Улсын БСШУЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ы Ардын Засгийн газар, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ хамтран “Улаанбаатар-ӨМӨЗО-ы соёлын өдрүүд”-ийг 2008 оны 1 дүгээр сарын 15-18-нд Монгол Улсад зохион байгуулав. Уг арга хэмжээнд Монгол-Хятадын зуугаад жүжигчин хамтарч, 21 үзүүлбэр бүхий хөтөлбөртэй тоглолт хийж, нэгэн цогц концертыг хамтран тоглох шинэлэг хэлбэрийг ашиглаж, соёлын өдрүүдийн үйл ажиллагааг<sup>8</sup> хоёр талын телевизээр шууд дамжуулсан нь онцлог болж олны таашаалд нийцжээ.

Урлаг соёлын хамтын ажиллагаанд хоёр талын урлаг соёлын ажилтнууд, дуучин, жүжигчин, бүжигчин, яруу найрагч, зохиолч, найруулагч, телевизийн хөтлөгч, нэвтрүүлэгч, хамтлагууд оролцож, хамтарсан уран бүтээл хийж, ард түмний хоорондын найрамдалт харилцааг хөгжүүлэх, итгэлцлийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ы хоорондын соёл урлагийн салбарын үйл ажиллагаа өргөжин тэлж, хоёр орны ард түмний нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадвараа солилцох, итгэлцэл, ойлголцлоо гүнзгийрүүлэхэд чиглэж байна.

Монгол, Хятад хоёр улс хамтран монгол үндэстний соёлын өв болсон морин хуур, монгол ардын уртын дууг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрүүлж, ЮНЕСКО-гийн “Дэлхийн биет бус соёлын өвийн төрөл”-д 2003, 2005 онд тус тус бүртгүүлсэн юм. Энэ ажлыг цаашид эрчимжүүлэн хөгжүүлэх зорилгоор 2006 онд ӨМӨЗО-ы Хөх хотод Монгол, Хятад хоёр улс хамтран “Монгол ардын уртын дууг хамгаалах ажлыг зохицуулах комиссын хурлыг” зохион байгуулсан байна. Ийнхүү дэлхийн түүх, соёлын өв санд үнэтэй хувь нэмэр оруулсан монгол үндэстэн, нүүдэлчдийн соёл иргэншлийг дэлхий нийтэд таниулах анхны алхам болсон.

Биеийн тамир, спортын салбарт гурван улсын тамирчид, багш, дасгалжуулагч нар хамтран бэлтгэл хийх, харилцан туршлага солилцох, монгол үндэстний биеийн тамир спортын төрөл болон чөлөөт бөх, боксийн дасгалжуулагч багшаар удаан хугацаагаар Хятадад ажиллах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг олон талын үйл ажиллагаа явуулж ирлээ. Тухайлбал: 2009 онд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо анх удаа “Монгол туургатны үндэстний бөхийн наадам-2009” болж, Өвөр Монголд хоёр дахь удаагийн үндэстний бөхийн тэмцээнийг тус тус зохион байгууллаа. Уг наадамд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын монгол үндэстэн угсаатны бөхчүүд барилдаж, хурд хүчээ сорьж, цаашид уламжлал болгохоор шийджээ.

Эцэст нь Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын соёлын салбарын хамтын ажиллагааны хүрээнд шинжлэх ухаан, боловсрол, урлаг соёлын байгууллагуудын үйл ажиллагаа, хэлхээ холбоог улс тус бүрээр тоймлон хүргэхийг зорив. Үүнээс үзэхэд 3 улсын хувьд соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах хууль зүйн баримт бичгийн үндэс суурь нэгэнт тавигдаж, цаашид хөгжүүлэх таатай нөхцөл бүрджээ. Гэвч гурван улсын соёлын харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээ хөрш орнуудын өргөн удам нутаг дэвсгэрийг бүрэн хамрахгүй тухайн орны нийслэл эсвэл томоохон хотод соёлын өдрүүдийг хааяа нэг зохион байгуулах, байгууллага хоорондын уялдаа холбоо төдийхнөөр үргэлжилж, зөвхөн бүс нутаг, хил орчмын орон нутгийн хэмжээнд хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулж байна. Соёл нь ард түмний хооронд гүүрийн үүрэг гүйцэтгэдэг болохоор зөвхөн дээд байгууллагаас албан ёсны үйл ажиллагаа явуулснаас бараг дуучин, хамтлаг, хувь хүмүүс, телевизийн олон ангит кино жүжгээс ард түмэн тухайн орныхоо талаар ойлголтыг илүүтэй сайн тусгаж авах нь ажиглагдаж байна.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаа харьцангуй өргөжиж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь хоёр хөршийн хил залгаа монгол туургатан ард иргэдийн нийтлэг хэл, соёл, түүхэн уламжлал, ёс заншил, ахуй амьдралын хэв загварын давуу байдал, бие биеэ ойлгоход дөхөмтэй байдал зэрэг нь илүү чухал үүрэг гүйцэтгэхэд нөлөөлдөг. Энэхүү



давуу байдал, бие биеэ харилцан нөхөх, дутууг гүйцээх, мартагдсан соёлын өвийг сэргээх боломжийг оновчтой ашиглан 3 улсынхаа соёлын хамтын ажиллагааг улам эрчимжүүлж, нийт монгол туургатны соёл иргэншил, соёлын өвөрмөц уламжлал, ёс заншлыг хамгаалж, хадгалж үлдэх, өнөөгийн дэлхийн соёл иргэншлийн хөгжилд нийцүүлэхийн тулд шинэчлэн баяжуулах талаар хамтран ажиллаж, үйл ажиллагааны хүрээнд монгол ардын аман зохиол, туульс болон монгол үндэстний хамтарсан урлаг соёлын бүтээгдэхүүнийг олон улсын тавцанд гаргах улмаар дэлхийн зах зээлд борлуулах цаг нэгэнт болжээ.

Гагцхүү олон улсын тавцанд гарч, урлаг соёлын бүтээгдэхүүнээ борлуулахын өмнө эхлээд хоёр хөршийнхөө асар том зах зээлд гарч, өргөн уудам нутаг дэвсгэрийн нь гүн рүү нэвтрэн орж, соёлынхоо хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд юуны өмнө Монгол Улс, монголчуудын баатарлаг түүх, соёл уламжлалын талаархи хоёр хөршийн маань нийт ард түмний оюун мэдлэг, танин мэдэхүйн хангалтгүй, буруу зөрүү ойлголттой байдлыг арилгах нь чухал. Хоёрдугаарт, манай улсын соёл урлагийг тогтвортой хөгжүүлэх төрийн бодлого, санхүү-эдийн засгийн боломж болон хэлний бэрхшээл, өөрсдийн идэвхи санаачилга, сурталчилгааны дутмаг байдлаас улбаалсан соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа их төлөв хил хязгаарын хүрээнд явж ирснийг өөрчлөх цаг болжээ. Монгол, Орос, Хятад 3 улс соёлын хамтын ажиллагааныхаа цар хүрээг улам тэлж, хөгжлийн шинэлэг хэлбэрийг тал талаасаа идэвхи санаачилгатай эрэлхийлж, улс үндэстэн бүрийнхээ түүх соёлын онцлогийг улс орон бүрт харилцан адил сурталчилах нь улс төр, эдийн засаг болон бусад салбарын харилцаа хамтын ажиллагаанд итгэлцэл, ойлголцлыг гүнзгийрүүлэхэд чухал хүчин зүйл болох юм.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Монгол-Оросын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл (1990-2001) УБ., 2001
2. “Зууны мэдээ” сонин. 2008.04.15
3. “Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа” УБ., 2009 142-р тал.
4. “Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд 1991-2004” УБ., 2006
5. “Өдрийн сонин”. сонин 2009.03.23
6. “Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд 1991-2004 он. УБ., 2006 он
7. Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтаа” УБ., 2009. т. 29
8. “Солонго” сэтгүүл. 2008.2, №164